



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 460 дугаар тогтоолд доор дурдсан агуулгатай 6 дугаар заалт нэмсүгэй:

“6.Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн худалдан авах ажиллагааны газраас Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “II.2.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний “Сэлбэ сэргэлт” төслийн ТЭЗҮ боловсруулах худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг Нийслэлийн Засаг даргад шилжүүлэн хэрэгжүүлэхийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.”

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН